

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 11 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Г 2009 оны 12 дугаар сард зохион байгуулах 7
давтан сургалтын төлбөрийн хэмжээнд
өөрчлөлт оруулах тухай

Санхүү, эдийн засгийн хямралт байдал, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд үүсээд буй хүндрэл, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон мэргэжилтнүүдээс гаргасан хүсэлтийг тус тус ТЭМДЭГЛЭН,

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ын 3.8 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. 2009 оны 12 дугаар сард зохион байгуулах үнэт цаасны зах зээлд ажиллах эрх авсан мэргэжилтнийг давтан сургах сургалтын төлбөрийг тухайлан 100 000 /нэг зуун мянган/ төгрөг болгож бууруулан тогтоосугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН